


**ЧИН УЛСЫН ҮЕИЙН НЭРТ ЭРДЭМТЭН САЙШАНГАА БОЛОН
ТҮҮНИЙ ХЭЛШИНЖЛЭЛИЙН ЗОХИОЛ БҮТЭЭЛИЙН ТУХАЙ**

Цэцэнбаатар (Өвөр монголын их сургууль)

Чин улсын үед монгол хэл бичгийн судалгаа нэлээд эрчимтэй хөгжиж, монгол хэл шинжлэлийн түүхэнд нэр нөлөө ихтэй хэл бичгийн эрдэмтэд өдий төдий цолгорсоноор үл барам, монгол хэл бичгийн тухай судалгааны зохиол бүтээл ч олон гарсан билээ. Гэхдээ тэр үеийн монгол хэл бичгийн судалгаа нь Энэтхэг, Төвдөөс уламжлалтай ба Манж, Хятадын хэл шинжлэлийн нөлөөг хүртсэн гэх хоёр урсгал бүлэгт салбарласан байдаг. Энэтхэг, Төвдөөс уламжлал бүхий монгол хэл шинжлэлийн эрдэмтдэд “Огторгуйн маань”-ийг зохиосон Үзэмчин Данзандагва, “Хэлний чимэг”, “Сарны гэрэл” зэргийг зохиосон Алшаа Агваандандар, “Алтан толь”-ийг зохиосон Авга Лхамсүрэн нар багтлалцах бөгөөд Манж, Хятадын хэл шинжлэлийн нөлөөг хүртсэн эрдэмтэд гэвэл “Гурван зүйлийн үг хадмал үзэхэд хялбар болгосон бичиг”-ийн зохиогч утга үнэн гүн гэгч Жин Жай Гүн (敬公) жич түүний хөвгүүн Фүгюнь (富俊), “Монгол үсгийн бүгд тайлбар бичиг”-ийн зохиогч баруун Түмдийн Галсан хийгээд Монгол бичгийн чухлыг заасан бичиг”-ийн зохиогч Сайшангаа жич түүний эцэг Жин Хуй (景輝) нарыг дурдаж болно. Дээр дурдсан эрдэмтдийн дотроос Сайшангаагийн тухай, мөн түүний зохиол бүтээлийн талаар судалсан өгүүлэл зохиол цөөвөр бий боловч нягтлууштай зүйл бас олон байгаа. Ийнхүү энд холбогдол бүхий түүх сурвалжид тулгуурлан, Сайшангаа болон түүний хэл шинжлэлийн зохиол бүтээлийн тухай товчхон танилцуулахыг зорилоо.

Нэг. Сайшангаагийн товч намтар

Сайшангаа 1794 онд төрсөн, өргөсөн нэр Хэ Тин (汀), Чин улсын үеийн монгол найман хошууны нэг---Шулуун хөх хошууны хүн. Тэрээр нийслэл хотноо сурвалжит өрхөд төрж өссөн бөгөөд хар багаасаа Манж, Монгол, Хятад бичиг сурч, 1816 онд улсын шалгуулаар дамжин орчуулгын өргөгсөд болов. Тэгээд тэр урьд хожид гадаад монголын төрийг засах явдлын яамны бичээч, сайд нарын зөвлөлийн бичгийн дэслэн унших сайд, тэргүүн зэргийн хиа, Хамилын хэрэг эрхэлсэн сайд, хошууг захирагч сайд (дүтүн), цахарын дүтүн зэрэг тушаалд байв. 1831 оноос хойш тэрээр олон



*Өвөрмонголын Их Сургууль

газраар тойрон явж, авилгач ноёдыг шийтгэх ба хилсдэгсэдийг цагаатгах ажлыг голч бөгөөд хянамгай хийснээс Чингийн төрийн сайшаал хөхүүлэлийг олонтаа хүртэж, зэрэг жинс нь ч залгаагаар ахиж нэмэгдсээр байв. Энэ зуур тэр бас төрийн түүхийн ордны ерөнхий харгуулагч, ерөнхий хэрэг мэдэгч, орчуулгын шалгуулийн шалгагч түшмэл, орчуулах ордын сайд зэрэг бичгийн түшмэлийн сууринд ажиллаж байв. Сайшангаа 1841 онд (анхдугаар удаагийн хар тамхины дайны сүүлч үе) Тяньжин, Шанага боомт зэрэг газарт томилогдон хүрч, сэргийлэн хамгаалах ажлыг хариуцаж байв. Дараа жил нь Английн цэрэг Жэжян мужийг товтолж далай дагуу орон түгшүүртэй болсноо Сайшангаа Тяньжинд байцаагч түшмэлээр томилогдож, далайн сэргийлэлтийн хэрэг явдлыг хариуцжээ. “Нанжины гэрээ” тогтсоны дараа тэрээр нийслэл хотдоо буцаж, сангийн явдлын яамны эрхэн сайд, явган цэргийн бүгдийн даргаар томилогдон ажиллав. 1851 онд Сайшангаа Вэнь Хуа Дянь харшийн бичгийн эрхэн сайд ба цэргийн тухайн тэргүүлсэн сайдаар дэвшиж, сангийн яамыг хариуцав. Тус жил түүхэнд алдартай Тай Пин Тянь Гүөгийн тариачны хөдөлгөөн өрнөсөнд Сайшангаа дахинтаа байцаагч түшмэлээр Хунаньд томилогдон дайтсан боловч бослогчдод ялагдсанаас зэргээ хусуулж, хөрөнгөө хураалган, хүндээр яллагдсан байна. Сүүлээр нь Хорчин нутагтай шадар сайд Сэнгэричений гар дор хэдэн жил хүчин зүтгэл өргөж, ялаа гавъяагаар тайлсанаас 1861 онд Шулуун улаан хошууны монгол дүтүнгээр томилогджээ. 1875 онд Сайшингаа 82-той насан өөд болсон байна.

Сайшангаа бол Чин улсын Тэнгэр тэтгэгч, Сайшаалт Ерөөлт, Төр гэрэлт, Түгээмэл элбэгт, Бүрэнт засагч, Бадруулт төр зэрэг зургаан төрийг сундалсан том түшмэл билээ. Тэрээр “Гадаад монголын төрийг засах явдлын яамны дүрэм хууль” зэрэг засаг захиргааны хууль дүрмийг тогтоох ажилд голлон оролцож, ялангуяа бичгийн эрхэн сайд ба цэргийн тухайн тэргүүлсэн сайдын хоёр их өндөр тушаалд байсан явдал түүний байр суурь маш дээгүүр байсан гэдгийг гэрчилнэ. Чингийн төрд энэ хоёр тушаалыг үүргэлсэн хүн эрх сүрээр ер нь манж хааны дараа л ордог. Чин улсын түүхнээ ийм өндөр тушаалд дэвшсэн найман монгол сайдын нэг нь даруй Сайшангаа билээ.

Хоёр. Сайшангаагийн овог угсаа

Сайшангааг 阿 特 (Alute) овогтон гэж Хятад түүх сурвалжид тодорхой тэмдэглэсэн нь буй. Энэ овгийг “Алтад” овог гэж зарим ном зохиолд тайлбарласан байхад бас зарим бүтээлд түүнийг “Монголын нууц товчоон”-д гардаг “Арулад” хэмээх овог аймгийн нэртэй холбож үзсэн ч байдаг. Чухам аль нь зөв болохыг хойшдын судалгаагаар тодорхой үр дүнтэй болгох явдал шаардагдаж буй боловч “Арулад” овог хэмээн үзэгсэд нэн олон байдаг. “Чин улсын нэвтэрхий ойллого, овог аймгийн хураангуй, монгол найман хошууны овог” хэмээх хятад сурвалж бичигт тэмдэглэсэнээр бол, Alute овогтон цахар нутагт үе улиран оршин суурьшиж байжээ. Энэхүү тэмдэглэлээс үзэхэд, Сайшангаагийн өвөг дээдэс нь Манж Чинд орж өгөхөөс өмнө Монголын цахар түмний харъяат байсан гэж төсөвлөж болно. Учир нь Чин улсын үед, найман хошууны монголчуудыг тэдний нутаг аймаг буюу уугуул нутгаар нь “Цахарт үе улиран нутаглаж байв”, “Харчинд үе улиран суурьшиж байв” гэх мэтчилэн тэмдэглэж бичдэг нь ерөөс зуршил билээ. Энэ дашрамд дуурдахаас арал хойгийн “арал” гэдэг үгнээс гаралтай “Арулад” хэмээх эртний монгол овог эдүгээгийн цахар нутгийн Хөвөөт шар хошуунд ч өргөн тархаж буй.



Сайшингаагийнх удмаараа бүр Чингийн төрд дээгүүр байр суурьтай явсан сурвалжит айл өрх байжээ. Түүний эцэг Жин Хуй бол Сайшаалт ерөөлтийн 7-р он, өөрөөр хэлбэл 1802 оны өргөгсөд, гадаад монголын төрийг засах явдлын яамны тэмдэглэгч түшмэл, харъяат аймгийг даасан ариутгах хэлтсийн туслагч түшмэл, үйлдэх явдлын яамны жигүүрийн сайдаас авахуулан сангийн яамны эрхэн

сайд, дүтүн зэрэг тушаалд байсан бөгөөд Сайшаалт ерөөлтийн үед Манж, Хятад, Монгол 3 хэлний толь бичиг найруулж байсан бичгийн эрдэмтэн байжээ. Тэр бас Өрөөсөн чулуун хаалганы өртөөнд алба хааж байсан бөгөөд Төр гэрэлтийн 3-р он буюу 1823 онд Төвдөд томилогдон тушаал үүргэлжээ. Сайшангаагийн гутгаар хөвгүүн Чүн Чи (崇 己) бол мөн Чин улсын үеийн нэрт монгол түшмэл, Мүгдэний жанжин, сангийн яамны эрхэн сайд, түшмэдийн яамны эрхэн сайд хүртэл дээд зэргийн тушаалд байсан бөгөөд Ци Ши Тайхүү 慈禧太后-гийн өргөж гаргасан Хуан Тайзцы (хааны суурин залгамжлах хөвгүүн) Айшин Гиоро овогт Пү Жюнь (溥 俊) -ий багш нь байжээ. Найман улсын холбоот цэрэг Бээжин хотод цөмрөн орж ирсэн тэр жил, өөрөөр хэлбэл 1900 онд Чүн Чи арга бус Бао Динг хотод дутааж очсон бөгөөд эцэстээ тэнд биеэ хорлосон байна. Тэрээр Бүрэнт засагчийн 3-р он буюу 1864 оны шалгалтад эрхэм шилдэг (正 元, шалгуулийн тэргүүн байранд тодрогч)-ээр шалгарч, бүхий л Чин улсын 200 гаруй жилийн түүхэн дэх цорын ганц монгол эрхэм шилдэг болж тодорсон байна.



Сайшангаагийн охин, Чүн Чигийн охин дүү нь 1872 онд 16-тайдаа Бүрэнт засагч хааны сул хатан болсон бөгөөд 19 наснаасаа бэлэвсэрч, 1921 онд 65-тай нас барав.

Чүн Чигийн охин нь Буян гэгч нэртэй, 1872 онд 19 настайдаа Бүрэнт засагч хаанд мордож гол хатан нь болсон Шяо Жэ И Хуанхүү (孝 哲 毅 皇 后) бөлгөө. Гэвч төрийн эрхийг эзэрхсэн Ци Ши Тайхүү (хааны эх) түүнд дургүй байсан бөгөөд элдэв шалтгаар хаанд ойртуулахгүй тарчилган зовоож байжээ. Бүрэнт засагч хаан 1874 онд нас барсаны дараа, 22-хон настай тэрээр Ци Ши Тайхүүгийн харгис хэрцгий хардлагаар арга бус биеэ хорлосон байна. Ийнхүү Сайшингаа, Чүн Чи эцэг хөвгүүн хоёр үеэрээ бүр Бүрэнт засагч хааны хадам эцэг нь байжээ.

Гурав. Сайшингаагийн хэлшинжлэлийн зохиол бүтээл

Сайшингаа бол Чин улсын төрд насан туршид зүтгэсэн монголын дээд түшмэдүүдийн нэг нь болохоор барахгүй, монгол хэл бичгийн судалгаанд үлэмж зүтгэлтэй эрдэмтэн хүн байжээ. Төр гэрэлтийн 28-р он буюу 1848 онд модон бараар хэвлэгдсэн “Монгол бичгийн чухлыг заасан бичиг” гэдэг 4 ботид цуврал номыг Сайшингаа найруулан эмхэтгэсэн бөгөөд энэхүү эмхэтгэлд нь “Монгол үсгийн журмыг салгасан бичиг”, “Монгол бичгийн хуульт дүрэм бичиг”, “Үзэхүйдүр хялбар болгосон бичгийн ташаарсан явдлыг залруулсан бичиг”, “Үзэхүйдүр хялбар болгосон бичгийн тасалдсаныг ану нөхөлхийлсэн бичиг” гэх 4 бүтээл орсон бөгөөд бас нэлээд хэдэн хавсралт дагалдуулжээ. Үүнд эхний 2 бүтээл нь Сайшингаагийн эцэг Жин Хуйгийн үлдээсэн бүтээл, Сайшаалт ерөөлтийн үе (1796-1821)-д бичигджээ. Гэхдээ Сайшингаа эцгийнхээ энэ хоёр зохиолд нөхөлт, засалт оруулсан байна. Харин сүүлчийн хоёр нь Сайшингаагийн өөрийнх нь бүтээл юм. Эдгээр зохиол бүтээлүүд Дундад улсын Бээжин, Хөххот, Далянь, Шанхай зэрэг хотодын номын сангуудад байхаар барахгүй, Монгол, Япон, Орос зэрэг бусад улсад ч уламжлагдан хадгалагдаж буй.

“Монгол бичгийн чухлыг заасан бичиг”-ийн 1, 2-р боть нь “Монгол үсгийн журмыг салгасан бичиг” юм. Тус бүтээлийн өмнө нь манж, хятад, монгол 3 хэлээр Сайшингаагийн бичсэн өөрийн оршилтой. Тус бүтээл дээд доод 2 дэвтэр, 193-н нүүр, нийт 1514 толгой үгийг манж, хятад, монгол 3 хэлээр харьцуулсан, манж үсгийн цагаан толгойгоор дараалуулсан толь бичиг юм. Тус толь бичигт өдөр тутмын хэрэглэгээний байнгын үгсийг хураамжлан оруулсанаас гадна, тийн ялгалын дагаварыг ч багтаасан байна. Мөн олон утгат үгсийн утга нэг бүрийг нэг нэгээр орчуулан илтгэв. Жин Хуйгийн найруулсан уулын ном нь зөвхөн манж, монгол толь бичиг байсан, хятад орчуулгыг Сайшингаа нэмсэн юм.



“Монгол бичгийн хуульт дүрэм бичиг” болвоос “Монгол бичгийн чухлыг заасан бичиг”-ийн 3-р боть нь. Тус номд манж, монгол хоёр хэлний үйл үгийн янз бүрийн хувилалыг манж хэлний ala-(хэлэх) болон монгол хэлний “хэл-” хоёрын жишээгээр харьцуулан үзүүлж, нийт 147 зүйлд хураангуйлсан байна. Хавсралтын хэсэгт Жин Жай Гүн, Фүгюнь нарын найруулсан “Гурван зүйлийн үг хадмал үзэхүйдүр хялбар болгосон бичиг” дэх үйл үгийн хувилалын талаарх алдаа мэдгийг зассан бөгөөд тэгэхдээ холбох эгшгийн дүрэмд холбогдох зөв бичилгийн агуулгуудыг тодорхой жишээн дээр үзүүлсэн байна. Тус ботийн эхэнд монгол үсгийн цагаан толгой, хятад хэлний авиаг тэмдэглэх үсгүүдийг нийт 127 жагсаажээ. Гэхдээ

эгшгийг “Гурван зүйлийн үг хадмал үзэхүйдүр хялбар болгосон бичиг”-тэй адилаар дүрсээр нь “а, э, и, о-у, ө-ү” гэж 5-хан үсэгт хураангуйлсан явдал монгол хэлний бодит байдалд зохицохгүй болсон байна.

“Үзэхүйдүр хялбар болгосон бичгийн ташаарсан явдлыг залруулсан бичиг” хийгээд” Үзэхэд хялбар болгосон бичгийн тасалдсаныг ану нөхөлхийлсэн бичиг” хэмээх хоёр зохиол “Монгол бичгийн чухлыг заасан бичиг”-ийн 4-р ботид хамт түүвэрлэгдэн оржээ. Эхний зохиолдоо Сайшингаа “Гурван зүйлийн үг хадмал үзэхүйдүр хялбар болгосон бичиг” дэх алдаа ташааг зассан бөгөөд засалт нь нийт 297 толгой үгэнд холбогдсон байна. Засвар оруулсан зүйлд монгол, хятад үсгийн ташаа бичлэг, тийн ялгалын дагаварын ташаарал, орчуулгын алдаа мадаг, тухайлбал монгол, манжийг хольсон ба монгол үгийг манж үгээр орлуулсан зэрэг зүй зохисгүй зүйл харагдана. Хоёр дахь зохиолдоо зохиогчоор “Хааны бичсэн манж үгний толь бичиг”-т тулгуурлан, “Гурван зүйлийн үг хадмал үзэхүйдүр хялбар болгосон бичиг”-т орсонгүй орхигдсон 828 үгийг шинээр нөхөж, тэдгээрийг мөн манж, хятад, монгол 3 зүйлийн үсэг бичгээр жагсааж тавьжээ. Тус ботийн эхэнд Сайшингаагийн манж, монгол, хятад 3 хэлээр бичсэн оршилтой, түүнд “Гурван зүйлийн үг хадмал үзэхүйдүр хялбар болгосон бичиг”-ийн найруулагдаж хэвлэгдсэн явцын тухай товчхон танилцуулж уг толь бичгийн ач холбогдлыг үнэлэн, алдаа ташааг нь засварлах учир шалтгаан зэргийг дурдсан байна.

Энэ мэтчилэн “Монгол бичгийн чухлыг заасан бичиг” нь нийт 4 хэсэгт хуваагдах бөгөөд монгол хэл шинжлэлийн түүхэн дэх толь бичиг, хэл зүйг хамтруулсан чухал дурсгал бичиг юм. Энэхүү бүтээл хэдийгээр хуудас хэмжээгээр нимгэн, тольчилсон үгийн тоо цөөхөн боловч манж, монгол хэл бичиг сурах ба орчуулга хийхэд чухал гарын авлага болж байжээ.

Сайшингаагийн бас нэг чухал бүтээл нь “Монгол үсгийн хураасан бичиг” хэмээх монгол, хятад, манж 3 хэлний томоохон хэмжээний толь бичиг юм. Тус толь бичиг Түгээмэл элбэгтийн тэргүүн он (1851) ба Бүрэнт засагчийн 8-р он (1869) –ны гар бичмэлээр уламжлагдсанаас бус жинхэнээр барлагдаагүй. Түгээмэл элбэгтийн тэргүүн оны гар бичмэл нь нийт 16 боть, үдмэл дэвтэр, нийт 1121 нүүр, 18924 толгой үгтэй. Манж, монгол, хятад 3 хэлээр бичсэн зохиогчийн өөрийн оршилтой. Уг оршилд Жин Жай Гүн, Фүгюнь нарын найруулсан “Гурван зүйлийн үг хадмал үзэхүйдүр хялбар болгосон бичиг”-ийн үнэ цэнийг өндөр үнэлсэний хамт, тус толь бичиг найруулсан зорилго ба явц зэргээ тодорхойлжээ. Оршилоос үзэхэд, Сайшингаа залуу бага насандаа эцэг Жин Хуйд туслан монгол бичиг харыг манжаар орчуулж өгдөг байсан ба 1823 онд эцэг нь Төвд орноо албан ажилд томилогдсоноос хойш гадаад монголын төрийг засах явдлын яамны бичээчийн хувиар манж, монгол бичиг харын орчуулгыг бие даан гүйцэтгэх болсон байна. Тэр цагаас эхлэн Сайшингаа орчуулах явцад тохиолдсон хүчиртэй асуудлуудыг бүртгэн, “Хааны бичсэн дөрвөн зүйлийн үсгээр хавсарсан манж үгний толь бичиг” тэргүүтнээр лавлалт

болгож, урьд хожид 30 гаруй жилийн цаг зарцуулж байгаад энэхүү толь бичгийг найруулж гаргасан байжээ. Гэвч тэр нас болтлоо энэ бүтээлээ барлуулж амжсангүй. Сайшингаагийн энэ толь бичиг түүнээс хожуу үеийн толь бичгүүдэд маш их нөлөө үзүүлсэн юм. Жишээлбэл Чин улсын Бадруулт төрийн 17-р он буюу 1891 онд барлагдсан “Зарлигаар тогтоосон монгол үсгийн хураасан бичиг” бол гадаад монголын төрийг засах явдлын яамны эрхэн сайд Сүн Сэнь (松森) тэргүүтэй олон түшмэд хаанд айлтгаж, Сайшингаагийн “Монгол үсгийн хураасан бичиг”-ээр эх дэвтэр болгон мөн бусад толь бичгүүдээр лавлалт болгож байгаад найруулж гаргасан толь бичиг юм. Мөн тус жил, гүүш лам Ли Хун (李, өргөсөн нэр 品三) нар бас Сайшингаагийн “Монгол үсгийн хураасан бичиг”-т тулгуурлаж байгаад “Монгол үгний бүгд хураасан бичиг”-ийг найруулан хэвлүүлсэн байна. Ер нь Чин улсын сүүлч үеэр иймэрхүү “Хураасан бичиг” гэж нэрлэгдсэн монгол, хятад 2 хэлний буюу монгол, хятад, манж 3 хэлний толь бичгүүд хэд хэдэн зүйл гарсан бөгөөд тэдгээр нь бүр шууд буюу дамаар Сайшингаагийн “Монгол үсгийн хураасан бичиг”-ээс улбаалсан юм.

Keywords: Saishangga; Qing dynasty; Linguistic works

Abstract: There were many famous Mongolian scholars in the history of the Qing dynasty and they left a lot of scholarly works on humanities and natural sciences. Of those famous people, Saishangga (Sayišangγ-a, 1794-1875) was a cabinet minister as well as a civil official. In some historical documents, Saishangga’s surname was recorded as Alute (阿特), which should be the Mongolian surname Arulad affiliated to the Chakhar tribe. Saishangga was from the Pure Blue Banner (siluγun köke qosiyu) which was one of the Eight Mongolian Banners. He had spent a lifetime serving as a chief official of the Qing government. Saishangga’s father Jinghui was also a cabinet official of the Qing dynasty while his son Chongqi was the only Number One Scholar (元) in the history of the Qing dynasty. Chongqi’s daughter Buyan was married to Emperor Tongzhi together with her aunt. Hence both Saishangga and Chongqi were fathers-in-law of Emperor Tongzhi. On the other hand, Saishangga was a famous linguist of that time. His linguistic works includes “Mongγol bičig-ün čiqula-yi jiyaysan bičig” and the Mongolian-Chinese-Manchu dictionary named “Mongγol üsüg-ün quriyaysan bičig”. The first one is a serial works with four volumes, of which the first two were written by Saishangga’s father Jinghui and revised by Saishangga while the last two were written by Saishangga himself. These works are also small-sized dictionaries with some grammatical and orthographical explanations. Saishangga’s these linguistic works rank very high in the history of Mongolian linguistic studies.

Ном зүй

1. “Mongγol sudulul-un nebterkei toli (üge kele üsüg bičig), Öbör mongγol-un arad-un keblel-ün qoriy-a, Kökequta, 2004 on.
2. А. Лувсандэндэв, Б. Амаржаргал. “Монгол үсгийн журмыг салгасан бичиг” хэмээх толь. Бамбадоржийн Амаржаргалын “Халх аялгууны үгийн сан, утгын судалгаа” номоос. УБ. 2007.
3. 春花; 《代蒙文典研究》, 宁民族出版社, 2008年。
4. (高宗 敕撰《朝通志》卷六“氏族略·蒙古八旗姓”。
5. 栗林均編《蒙文倒綱》(資料編·原本印影)、東北大東北アジア研究センター、仙台、2012年。